



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Туулын хишиг” ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/011/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.open.audit.mn
Улаанбаатар хот
2025 он

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор:	Ч.Энхтуяа
Утас: 70363040	Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Аудитын менежер:	Б.Батмөнх
Утас: 70363036	Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
Аудитыг гүйцэтгэсэн:	Пийк Ом Аудит ХХК
Аудитор	Б.Наранчимэг
Утас: 99052418	Цахим хаяг: cheegii9989@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	8
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллагын үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	9
3.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	11
4. Аудитын тайлан.....	
4.1 Ерөнхий зүйл.....	
4.2 Материаллаг байдал.....	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
5. Аудитын илрүүлэлт.....	14
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	0

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ТБОНОХБАХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

“ТУУЛЫН ХИШИГ” ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Э.ШИНСАНДАГ ТАНАА

2025.03.14 № СЭА-2025/011/НА-СТА-ОНӨҮГ
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Туулын хишиг ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Туулын хишиг ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар дараах зөрчлүүд илэрсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс тайлант онд бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивээгүй, харилцагч нь тодорхой бус, олон жил дамнасан, насжилт өндөртэй өглөг, авлагыг шийдвэрлэх, шаардлагатай бол холбогдох байгууллага, албан

тушаалтанд хандаж данс бүртгэлээс хасах, барагдуулах талаар арга хэмжээ аваагүй,

- Харьцуулалтын аргаар худалдан авах босго үнээс давсан 140,850.0 мянган төгрөгийн нүүрсний худалдан авах ажиллагааг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн,
- Тайлант оны үйл ажиллагааны үр дүнгээр 91,014.6 мянган төгрөгийн алдагдал хүлээж, өөрийгөө санхүүжүүлж чадаагүй,

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант оны гүйцэтгэлээр айл өрхөөс 19,019.7 мянган төгрөгийн, аж ахуйн нэгж байгууллагаас 11,793.7 мянган төгрөг, төсөвт байгууллагуудаас 286,970.4 мянган төгрөгийн нийт 317,783.8 мянган төгрөгийн борлуулалтын орлого, сумын ЗДНХ-өөс 15,000.0 мянган төгрөгийн дэмжлэг төвлөрүүлж, 423,798.4 мянган төгрөгийн зардал гарган, 91,014.6 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Үйл ажиллагаанаас жил бүр алдагдал хүлээж, нийт алдагдлын дүнд үндсэн хөрөнгийн элэгдэл болон ажил үйлчилгээ, бараа материалын зах зээлийн үнэ ханшийн өсөлт тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаа боловч удирдлагын зүгээс алдагдлыг бууруулах арга хэмжээ авч ажиллаагүй, үйл ажиллагаа урсгалаараа явагдснаас голлон шалтгаалсан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 3,520.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, сумын Онцгой комиссын шийдвэрээр ЗДНХ-өөс халаалтын шугамын засварт 15,000.0 мянган төгрөгийн дэмжлэгийг хүлээн авч засварын ажилд зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

“Туулын хишиг” ОНӨААТҮГ-ын 2024 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 95.0 хувийн хэрэгжилттэйгээр тайлагнасан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	2,041,453,856.24	1,986,202,324.24
2	Эргэлтийн хөрөнгө	81,590,046.33	84,343,120.29
3	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,545,739.97	634,493.00
4	Дансны авлага	73,526,205.37	75,045,768.05
8	Бараа материал	6,518,100.99	8,662,859.24
13	Эргэлтийн хөрөнгийн дүн	81,590,046.33	84,343,120.29
14	Эргэлтийн бус хөрөнгө	1,959,863,509.91	1,901,859,203.95
15	Үндсэн хөрөнгө	475,167,509.91	417,163,203.95
23	Биет бус хөрөнгө	1,484,696,000.00	1,484,696,000.00
24	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,959,863,509.91	1,901,859,203.95
25	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,041,453,556.24	1,986,202,324.24
26	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	2,041,453,556.24	1,986,202,324.24
27	Өр төлбөр	126,704,490.41	142,467,832.37
28	Богино хугацаат өр төлбөр	125,537,810.41	142,467,832.37
29	Дансны өглөг	64,855,869.37	92,019,766.73
31	Татварын өр	38,196,763.67	50,448,065.30
32	НДШ-ийн өглөг	2,485,177.37	0.34
36	Урьдчилж орсон орлого	20,000,000.00	
41	Богино хугацаат өр төлбөрийн дүн	125,537,810.41	142,467,832.37
46	Бусад урт хугацаат өглөг	1,166,680.00	
48	Урт хугацаат өр төлбөрийн дүн	1,166,680.00	
49	Өр төлбөрийн нийт дүн	126,704,490.41	142,467,832.37
50	Эздийн өмч		
51	Өмч: а) төрийн	2,118,488,000.00	2,118,488,000.00
56	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	164,604,304.98	164,604,304.98
59	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	-368,343,239.15	-439,357,813.11
60	Тайлант үеийн ашиг, алдагдал		-91,014,573.96
61	Эздийн өмчийн дүн	1,914,749,065.83	1,843,734,491.87
62	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,041,453,556.24	1,986,202,324.24

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	315,562,913.13	317,783,838.87
2	Борлуулалтын өртөг	352,381,663.81	362,282,580.67
3	Нийт ашиг(алдагдал)	-36,818,750.68	-44,498,741.80
8	Бусад орлого	20,000,000.00	15,000,000.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	56,622,856.97	61,111,532.16
12	Бусад зардал	5,303,905.00	404,300.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	-78,745,512.65	-91,014,573.96
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-78,745,512.65	-91,014,573.96
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-78,745,512.65	-91,014,573.96

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
9	2023 оны 12-р сарын 31 -ний үлдэгдэл	2,118,488,000.00	164,604,304.98		-368,343,239.15	1,914,749,065.83
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө алдааны залруулга				20,000,000.00	20,000,000.00
11	Залруулсан үлдэгдэл					
12	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал /				-91,014,573.96	-91,014,573.96
13	Бусад дэлгэрэнгүй орлого					
14	Өмчид гарсан өөрчлөлт					
15	Зарласан ногдол ашиг					
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
17	2024 оны 12- р сарын 31-ний үлдэгдэл	2,118,488,000.00	164,604,304.98	0.00	-439,357,813.11	1,843,734,491.87

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	362,876,700.82	360,914,752.28
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	362,876,700.82	360,914,752.28
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	599,200.00	343,913,952.28
1.1.6	Бусад мөнгөн орлого	362,277,500.82	17,000,800.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	349,468,165.92	358,305,999.25
1.2.1	Ажиллагчдад төлсөн	126,496,548.00	99,544,742.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	31,902,205.00	33,330,717.40
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	118,982,041.23	209,414,172.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	48,593,374.06	
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		3,233,350.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	23,493,997.63	7,140,967.85
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		
1.2.9	Бусад мөнгөн зарлага		5,642,050.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	13,408,534.90	2,608,753.03
2.2	Мөнгөн зарлагын дүн	-13,595,600.00	-3,520,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	13,595,600.00	3,520,000.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-13,595,600.00	-3,520,000.00
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-187,065.10	-911,246.97
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,732,805.07	1,545,739.97
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,545,739.97	634,493.00

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

д/д	Үзүүлэлт	Хэм.нэгж	2023 оны гүйцэтгэл	2024 он		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Нийт борлуулалт		335,562.9	315,060.9	317,783.8	-2,722.9	100.9
	Үүнээс: Цэвэр борлуулалт	мян/төг	335,562.9	315,060.9	317,783.8	-2,722.9	100.9
	Төсвийн байгууллага	мян/төг	287,420.5	286,918.5	286,970.4	-51.9	100.0
	Айл өрх	мян/төг	15,612.7	15,612.7	19,019.7	-3,407.0	121.8
	ААН	мян/төг	12,529.7	12,529.7	11,793.7	736.0	94.1
	Хандив тусламжийн орлого	мян/төг	20,000.0		15,000.0		
2	Нийт зардал		414,308.4	426,345.0	423,798.4	2,546.6	99.4
	Үүнээс: а/Борлуулалтын өртөг	мян/төг	352,381.7	365,829.5	362,282.6	3,546.9	99.0
	б/ Ерөнхий удирдлагын зардал	мян/төг	61,926.7	60,515.5	61,515.8	-1,000.3	101.7
3	Цэвэр ашиг. алдагдал	мян/төг	-78,745.5	-111,284.1	-91,014.6	-20,269.5	81.8

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Туулын хишиг” ОНӨААТҮГ нь “Орхонтуул суманд үйл ажиллагаа явуулж буй аж ауйн нэгж, айл өрхийг дулааны эрчим хүч, ахуйн хэрэглээний улсын стандарт хангасан цэвэр ус олборлон түгээх, хэрэглээний улмаас гарсан бохир усыг татан зайлуулах ажлыг байнгын хэвийн найдвартай хангаж, эдийн засгийн алдагдлыг бууруулна” гэсэн эрхэм зорилготойгоор үйл ажиллагаа явуулж байна.

“Туулын хишиг” ОНӨААТҮГ-ын дүрэмд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сумын төв дэх төсвийн байгууллагуудын дулаан хангамж, тохижилт, орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалт, зарим засвар үйлчилгээг харилцан гүйцэтгэх, хяналт тавих,
- Сумын төв, хөдөөд газар тариалан эрхлэх, дулаан цэвэр усаар хангах иргэн, байгууллагатай гэрээ хийх, ашиглалтын төлбөр тооцоо хийх,
- Орон нутгийн өмчийн техник бусад хэрэгслээр төсвийн байгууллагад захиалгат үйлчилгээг мөн тогтоосон үнэ тарифаар үйлчилгээ үзүүлэх гэх мэт.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

“Туулын Хишиг ” ОНӨААТҮГ нь Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль Нийгмийн даатгалын багц хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон

нутгийн өмчийн тухай хууль, ТБОНӨХБАУХА тухай хууль, Эрчим хүчний тухай хууль зэрэг хуулиудыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр,
- Усны тухай хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр,
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр,

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө сул байна гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

"Туулын хишиг" ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

"Туулын Хишиг" ОНӨААТҮГ нь Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан *"Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"*-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий борлуулалтын орлого, өртгийн тооцоолол, хөрөнгө оруулалтын талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

"Туулын хишиг" ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 55,251.2 мянган төгрөгөөр буюу 2.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,545.7	634.5	-911.2
Авлага	73,526.2	75,045.8	1,519.6
Бараа материал	6,518.1	8,662.9	2,144.8
Үндсэн хөрөнгө	475,167.5	417,163.2	-58,004.3
Биет бус хөрөнгө	1,484,696.0	1,484,696.0	0.00
Нийт хөрөнгө	2,041,453.6	1,986,202.3	-55,251.2
Богино хугацаат өр төлбөр	126,704.5	142,467.8	15,763.3
Эздийн өмч	2,118,488.0	2,118,488.0	0.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	164,604.3	164,604.3	0.00
Хуримтлагдсан ашиг	-368,343.2	-439,357.8	-71,014.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,041,453.6	1,986,202.3	-55,251.2

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

- Мөнгө хөрөнгө дансны үлдэгдэл 634.5 мянган төгрөг болж 911.2 мянган төгрөгөөр буурсан нь үйл ажиллагааны зардалтай холбоотой байна.
- Авлага дансны үлдэгдэл 75,045.8 мянган төгрөг болж 1,519.6 мянган төгрөгөөр өссөн нь борлуулалтын авлага 3,165.9 мянган төгрөгөөр, цалингийн урьдчилгаа суутгаагүй 362.4 мянган төгрөг зэрэг нийт 3,528.3 мянган төгрөгөөр нэмэгдэж, шинээр үүссэн 2,008.7 мянган төгрөгийн авлагыг барагдуулснаас шалтгаалсан байна. Нийт авлагын 87.1 хувийг насжилт өндөртэй авлага, 9.3 хувийг айл өрх, аж ахуйн нэгжийн авлага, 3.6 хувийг газрын түрээсийн авлага эзэлж байна
- Бараа материалын дансны үлдэгдэл 8,662.9 мянган төгрөг болж 2,144.8 мянган төгрөгөөр өссөн нь 136,984.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон сумын Онцгой комиссын 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 01 дүгээр шийдвэрийн дагуу дулааны шугамын гэмтлийг засварлахад ЗДНХ-өөс 15,000.0 мянган төгрөгийн дэмжлэгийг хүлээн авч засварын материал авсан, үйл ажиллагаандаа 149,839.4 мянган төгрөгийн бараа материал түүхий эдийг зарцуулснаас шалтгаалсан байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 868,603.2 мянган төгрөг болж 3,520.0 мянган төгрөгөөр өссөн нь өөрийн хөрөнгөөр зөөврийн болон суурин компьютер худалдан авсантай холбоотой байна. Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 451,439.9 мянган төгрөг бөгөөд 417,163.3 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй байна.
- Өр төлбөр дансны үлдэгдэл 142,467.8 мянган төгрөг болж 15,763.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд татвар, шимтгэлийн өглөг 71,210.0 мянган төгрөгөөр, цахилгааны зардлын өглөг 60,297.6 мянган төгрөгөөр, цалингийн өглөг 123,976.5 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний зардлын өглөг 168,032.5 мянган төгрөгөөр зэрэг нийт 423,516.6 мянган төгрөгийн өр төлбөр

шинээр үүсч 407,753.3 мянган төгрөгийн өр төлбөрийг барагдуулсан зэрэг нь нөлөөсөн байна. Нийт өр төлбөрийн 25.7 хувийг насжилт өндөртэй эзэн холбогдогч нь тодорхойгүй, 36.8 хувийг бараа үйлчилгээний, 37.5 хувийг татварын өр төлбөр эзэлж байна.

3.5 Техник, эдийн засгийн зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу "Туулын хишиг" ОНӨААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Орхонтуул сумын Засаг дарга нь 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр "Туулын хишиг" ОНӨААТҮГ-ын даргатай гэрээ байгуулж 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 315,060.9 мянган төгрөгөөр, нийт зардлыг 426,345.0 мянган төгрөгөөр, алдагдлыг 111,284.1 мянган төгрөгөөр тооцож баталсан бөгөөд хөрөнгө оруулалтын 1 арга хэмжээнд 3,520.0 мянган төгрөг төлөвлөсөн байна.

Тайлант оны гүйцэтгэлээр айл өрхөөс 19,019.7 мянган төгрөгийн, аж ахуйн нэгж байгууллагаас 11,793.7 мянган төгрөг, төсөвт байгууллагуудаас 286,970.4 мянган төгрөгийн зэрэг нийт 317,783.8 мянган төгрөгийн борлуулалтын орлого, сумын ЗДНХ-өөс 15,000.0 мянган төгрөгийн дэмжлэг төвлөрүүлж, 423,798.4 мянган төгрөгийн зардал гарган, 91,014.6 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Үйл ажиллагаанаас жил бүр алдагдал хүлээж, нийт алдагдлын дүнд үндсэн хөрөнгийн элэгдэл болон ажил үйлчилгээ, бараа материалын зах зээлийн үнэ ханшийн өсөлт тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаа боловч удирдлагын зүгээс алдагдлыг бууруулах арга хэмжээ авч ажиллаагүй, үйл ажиллагаа урсгалаараа явагдснаас голлон шалтгаалсан байна.

Нийт орлогын төлөвлөгөөг 100.9 хувь буюу 2,722.9 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 423,798.4 мянган төгрөг болж зардлыг 2,546.7 мянган төгрөгөөр буюу 0.6 хувиар хэмнэсэн нь цалин шимтгэлийн зардал 90.4 мянган төгрөгөөр, тогтмол зардал 19,330.4 мянган төгрөгөөр, албан томилолтын зардал 128.0 мянган төгрөгөөр хэмнэгдэж хангамж бараа материалын зардал 997.3 мянган төгрөгөөр, урсгал засварын зардал 13,355.3 мянган төгрөгөөр, төлбөр хураамжийн зардал 2,649.5 мянган төгрөгөөр хэтэрснээс шалтгаалсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан

гаргана.” гэж заасны дагуу “Туулын хишиг” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд “Туулын хишиг” ОНӨААТҮГ түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн алдагдлын хэмжээг бууруулах, олон жилийн насжилттай авлага, өглөгийг барагдуулах арга хэмжээ авах, татварын өр төлбөрийг тайланд үнэн зөв тусгах зэрэг зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Пийк Ом Аудит” ХХК-ийн аудитор Б.Наранчимэг гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Туулын хишиг” ОНӨААТҮГ нь 2024 оны санхүүгийн тайланг 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр “Пийк Ом Аудит” ХХК-д ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн 414,308.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,143.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.3.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлд тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 19 төрлийн 179 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.3.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд 140,850.0 мянган төгрөгийн нүүрсний худалдан авалтыг “Голд хангай” ХХК-тай шууд гэрээ байгуулан гүйцэтгэсэн нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх *“Төндөр шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно”*, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар 1 дэх *“Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа 20.0 сая төгрөг”, “Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа 100.0 сая төгрөг”* гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйл 42.1 дэх *“...хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”* гэсэн заалтын дагуу дарга Э.Шинсандаг, нягтлан бодогч П.Соль нарт сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

“Туулын Хишиг” ОНӨААТҮГ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- *Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,*
- *Ажилчин албан хаагчдад олгодог нэгж, холбооны зардлыг багасгасан,*
- *Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй ,*
- *Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан гэх мэт.*

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Пийк Ом аудит” ХХК нь 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 921 дүгээр албан бичгээр “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” захидлыг тус байгууллагад хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ төлбөрийн цахим баримтыг бүрдүүлэх, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулах, насжилт өндөртэй найдваргүй авлагыг барагдуулах ажил зохион байгуулах, батлагдсан төлөвлөгөөг бүрэн биелүүлж ажиллах зэрэг 4 албан шаардлага, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах 1 зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	4	94,010.9			
Зөвлөмж	1				
Нийт дүн	5	94,010.9			

Өмнөх аудитаар өгсөн 4 албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтыг үндэслэн дарга Э.Шинсандаг, нягтлан бодогч П.Соль нарт сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулга

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой дараах 434,346.7 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

- Мөнгөн гүйлгээний тайланд борлуулалтын орлогыг бусад орлогоор тусгасан 326,913.2 мянган төгрөг,
- Мөнгөн гүйлгээний тайланд зардлын ангиллыг 67,746.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгасан,
- Үндсэн хөрөнгө бэлтгэсэн 3,520.0 мянган төгрөгийг мөнгөн зарлагаар илэрхийлж хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээг буруу илэрхийлсэн,
- Өмнөх жилд үнэ төлбөргүй хүлээн авсан 20,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг урт хугацаат өр төлбөр үүсгэж бүртгэсэн,
- Нягтлан бодох бүртгэлийн бичилтийн алдаанаас 1,166.7 мянган төгрөгийг авлага, өр төлбөрөөр давхар бүртгэсэн,
- Сумын Онцгой комиссын шийдвэрээр ЗДНХ-өөс халаалтын шугамын засварт өгсөн 15,000.0 мянган төгрөгийн дэмжлэгийг борлуулалтын орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 118,112.2 мянган төгрөгийн зөрчил илэрч, 43,695.4 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 74,416.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллах 3 зөвлөмж хүргүүлээ.

5.2 Албан шаардлага

1. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр дараах зөрчлүүдийг давтан гаргасан байна. Үүнд :

- Тайлант онд 15,828.3 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивээгүй,
- Харилцагч нь тодорхой бус, олон жил дамнасан, насжилт өндөртэй 27,268.1 мянган төгрөгийн авлагыг шийдвэрлэх, шаардлагатай бол холбогдох байгууллага, албан тушаалтанд хандаж данс бүртгэлээс хасах талаар арга хэмжээ аваагүй байна.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *“Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”* 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *“Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах”*....., Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь *“зардал бодитой гарсан бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан баримт болон холбогдох бүртгэлээр баталгаажсан байх”*, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь *“Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйл 42.1 дэх *“...хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”* гэсэн заалтын дагуу дарга Э.Шинсандаг, нягтлан бодогч П.Соль нарт сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

2. Тайлант оны 5 дугаар сард худалдан авсан 599.0 мянган төгрөгийн үнэ бүхий 2.5 тн нүүрсийг тооцооны дансаар дамжуулагүйгээр шууд зардлаар бүртгэж, тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх *“Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”*, 5.1.4: *“үнэн зөв байх”* 13 дугаар зүйлийн 13.1 дахь *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг үндэслэн ажил гүйлгээг үнэн зөв бүртгэж, тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэх.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Хуримтлагдсан ашиг, алдагдал

1.1 Илрүүлэлт: Тайлант онд үйл ажиллагааны үр дүнгээр 91,014.6 мянган төгрөгийн алдагдал хүлээж, өөрийгөө санхүүжүүлж чадаагүй бөгөөд үйл ажиллагаа явуулах тусам алдагдлын хэмжээ нэмэгдэж байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь “*Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэнэ.....*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Тус газрын үйл ажиллагаанд санхүүгийн шинжилгээ хийх замаар зохион байгуулалт, менежментийг өөрчилж, өөрийгөө санхүүжүүлэн ажиллах.

2.Насжилт өндөртэй авлага, өр төлбөртэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Дулааны үнийн өсөлттэй холбоотойгоор 2018 онд үүссэн, төсөвт байгууллагуудаас авах 38,081.6 мянган төгрөгийн авлага, олон жил дамнасан, насжилт өндөртэй 32,084.4 мянган төгрөгийн өр төлбөрийг шийдвэрлэх талаар арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх “*Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана*” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*”, гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Авлага, өр төлбөрт дүн шинжилгээ хийж, барагдуулах арга хэмжээ авах.

3.НӨАТ-ын өр төлбөртэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт: МТА-ны “Байгууллагын татварын тодорхойлол”-д НӨАТ-ын өглөгийг 4,250.8 мянган төгрөгөөр дутуу тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах*” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж: Татварын байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулж, авлага, өр төлбөрийг үнэн зөв тайлагнах,

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

1. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1.Мөнгөн гүйлгээний тайланд борлуулалтын орлогыг бусад орлогоор тусгасан	1	326,913.2			1	326,913.2	1	326,913.2				
2.Мөнгөн гүйлгээний тайланд зардлын ангиллыг зөрүүтэй тусгасан,	1	67,746.8			1	67,746.8	1	67,746.8				
3. ҮХ олж бэлтгэсэн 3,520.0 мянган төгрөгийг мөнгөн зарлагаар илэрхийлж хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээг буруу илэрхийлсэн,	1	3,520.0			1	3,520.0	1	3,520.0				
4.Өмнөх жилд үнэ төлбөргүй хүлээн авсан тоног төхөөрөмжийг урт хугацаат ер төлбөр үүсгэж бүртгэсэн,	1	20,000.0			1	20,000.0	1	20,000.0				
5.Нягтлан бодох бүртгэлийн бичилтийн алдаанаас 1,166.7 мянган төгрөгийг авлага, ер төлбөрөөр тусгасан,	1	1,166.7			1	1,166.7	1	1,166.7				
6.Сумын Онцгой комиссын шийдвэрээр ЗДНХ-өөс халаалтын шугамын засварт өгсөн дэмжлэгийг борлуулалтын орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн	1	15,000.0			1	15,000.0	1	15,000.0				
Дүн	6	434,346.7			6	434,346.7	6	434,346.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Үүнээс												
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1. Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ төлбөрийн цахим баримтыг дутуу бүрдүүлсэн, харилцагч нь тодорхой бус олон жилийн насжилттай авлага, өглөгийг шийдвэрлэх арга хэмжээ аваагүй	1	43,096.4			1	43,096.4						
2. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс тайлант онд бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивээгүй, харилцагч нь тодорхой бус, олон жил дамнасан, насжилт өндөртэй өглөг, авлагыг шийдвэрлэх, шаардлагатай бол холбогдох байгууллага, албан тушаалтанд хандаж данс бүртгэлээс хасах, барагдуулах талаар арга хэмжээ аваагүй,	1	-							1	2		
3. Анхан шатны бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, санхүүгийн тайланд тусгасан	1	599.0			1	599.0						

4.Жил бүр алдагдалтай ажиллаж хуриитлагдсан алдагдлын хэмжээ нэмэгдсэн	1	-				1	-			
5.Олон жилийн насжилттай авлага, өр төлбөрийг барагдуулар арга хэмжээ аваагүй,	1	70,166.0				1	70,166.0			
6. МТА-ны "Байгууллагын татварын тодорхойлол"-д НӨАТ-ын өглөгийг дутуу тусгасан	1	4,250.8				1	4,250.8			
Дүн	6	118,112.2		2	43,695.4	3	74,416.8	1	2	

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Нүүрсний худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй.	1	140,850.0			1	140,850.0		
Нийт дүн	1	140,850.0			1	140,850.0		



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 298/А/1850385

Сүхбаатар

САА-2023/011/АА-СТА-ОЖОУТ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын "Туулын хишиг" ААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд хийсэн аудитаар өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс алдаа, зөрчлийг давтан гаргасан, холбогдох албан тушаалтнууд албан үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн, албан тушаалын эрх мэдлээ хэтрүүлэн ажилласан дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Тайлант онд 15,828.3 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивээгүй,
- Харилцагч нь тодорхой бус, олон жил дамнасан, насжилт өндөртэй 27,268.1 мянган төгрөгийн авлагыг шийдвэрлэх, шаардлагатай бол холбогдох байгууллага, албан тушаалтанд хандаж, данс бүртгэлээс хасах талаар арга хэмжээ аваагүй,
- Шууд худалдан авах босго үнээс давсан 140,850.0 мянган төгрөгийн нүүрсний худалдан авалтыг "Голд хангай" ХХК-иас шууд худалдан авсан,

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах"..., ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно", Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолын 1 дэх "Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа 20.0 сая төгрөг", "Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа 100.0 сая төгрөг", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх,

432504864


төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.2 -д “Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлнэ” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх зөрчлүүдийг гаргасан нягтлан бодогч П.Сольд холбогдох хуулийн дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг “Туулын хишиг” ААТҮГ-ын дарга Э.Шинсандагт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

Б.НАРАНЧИМЭГ

АЛБАН ШААРДЛАГА, ТӨЛБӨРИЙН АКТЫН БҮРТГЭЛ,
ХЯНАЛТЫН ХУУДАС

А. Албан шаардлага, төлбөрийн актын төсөл бэлтгэж, баталгаажуулах үеийн бүртгэл, хяналт

1.Ерөнхий мэдээлэл

1.1 Аудитын нэр	"Туулын хишиг" ААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн аудитын тайлан	1.2 Аудитын код	СЭА-2025/011/НА-СТА-ОНӨҮГ		
1.3 Аудит хийсэн үндэслэл	Төрийн аудитын тухай хуулийн 6.3.1, 8.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1	1.4 Аудитын төрөл	Санхүүгийн тайлангийн аудит		
1.5 Албан шаардлага / төлбөрийн актын дугаар	298/А.1350385	1.6 Огноо	2025.03.15	1.7 Мөнгөн дүн /төгрөгөөр/	-

1.8 Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох үндэслэл	Алдаа зөрчлийн товч утга	Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс алдаа, зөрчлийг давтан гаргасан, холбогдох албан тушаалтнууд албан үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн, албан тушаалын эрх мэдлээ хэтрүүлэн ажилласан.			
	Алдаа зөрчлийн ангилал	Хууль, тогтоомж зөрчсөн			
	Журмын заалт (4.2-оос аль тохирохыг оруулах)	4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.", 4.2.1.10: "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол"			
	Зөрчсөн эрх зүйн актын	Нэр	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль		
		Заалт	13.1, 20.2.5		
		Нэр	ТБОНӨХБАҮХАТ		
		Заалт	8.4		
	Үндэслэл болгосон эрх зүйн актын	Нэр	Төрийн аудитын тухай хууль		
		Заалт	21.1		
		Нэр	Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2020 оны А/95 дугаар тушаал		
		Заалт	4.2.1.11		

1.9 Төлбөр барагдуулах хэлбэр / төгрөгөөр/	Улсын төсвийн дансанд	1.10 Төлбөр, зөрчил барагдуулах огноо
	Орон нутгийн төсвийн дансанд	
	Тухайн байгууллагын дансанд	2025.09.15

2. Үндэслэл болгосон гол нотлох баримтын талаарх мэдээлэл


№	Нотлох баримтын нэр төрөл	Дугаар	Огноо	Тайлбар
1	Өр авлагын журнал		2024 он	
2	Худалдан авалтын тайлан		2024 он	

3. Аудитын баг болон хариуцагчийн талаарх мэдээлэл

№	Аудитын багийн		Хариуцагч			
	Овог нэр	Албан тушаал	Байгууллагын нэр	Албан тушаал	Овог нэр	Холбоо барих хаяг, утас
1	Б.Наранчимэг	Аудитор	"Туулын хишиг" ААТҮГ	Дарга, Ерөнхий нягтлан бодогч	Э.Шинсандаг П.Соль	99215462 91112706

4. Албан шаардлага, төлбөрийн акт бэлтгэх үеийн чанарын хяналт

4.1 Чанарын хяналт хийсэн тэмдэглэл

№	Албан тушаалтан	Огноо	Чанарын хяналтаар өгсөн санал зөвлөмж	Гарын үсэг
1	Тэргүүлэх аудитор			

2	Аудитын менежер		—	
---	-----------------	---	---	---

4.2 Албан шаардлага, төлбөрийн актыг хэвлэмэл хуудсанд хэвлэх зөвшөөрөл

№	Албан тушаал	Овог нэр	Огноо	Гарын үсэг
1	Тэргүүлэх аудитор	Ч.Энхтуяа		
2				

5. Албан шаардлага, төлбөрийн актыг баталгаажуулж, хүргүүлэх үеийн баримтжуулалт

№	Үзүүлэлт		Мэдээлэл оруулах хэсэг	Гарын үсэг	
1	Албан шаардлага, төлбөрийн актыг баталгаажуулсан тушаалын	Огноо			
		Дугаар			
2	Албан шаардлага, төлбөрийн актыг хүргүүлсэн албан бичгийн	Огноо			
		Дугаар			
3	Албан шаардлага, төлбөрийн актыг хүлээлгэн өгсөн	Огноо	2025.03.15		
		Ажилтны	Овог нэр		Б.Наранчимэг
			Албан тушаал		Аудитор
4	Албан шаардлага, төлбөрийн актыг хүлээн авсан	Байгууллагын нэр	"Туулын хишиг" ААТҮГ		
		Ажилтны	Овог нэр		Э.Шинсандаг
			Албан тушаал		Дарга
5	Албан шаардлага, төлбөрийн актын хэрэгжилтийг хариуцах	Газрын нэр	Пийк Ом аудит ХХК		
		Ажилтны	Овог нэр		Б.Наранчимэг
			Албан тушаал		Аудитор
6	Тооцоолсон зөвшөөрүүлсэн үр өгөөж	Санхүүгийн	Тоо		
			Дүн		
		Санхүүгийн бус үр өгөөжийн тоо			



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 299/А/250385
СЭА-2025/011/ӨА-СЭА-0904Т

Сүхбаатар

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын “Туулын хишиг” ААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Тайлант оны 5 дугаар сард худалдан авсан 599.0 мянган төгрөгийн үнэ бүхий 2.5 тн нүүрсийг бараа материалын дансаар дамжуулалгүйгээр шууд зардлаар бүртгэж, тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 5.1: “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална, 5.1.4: үнэн зөв байх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. Үүнд: 4.2.1.11: “Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй; 4.2.1.11: “Хууль тогтоомж,зөрчсөн” ” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

- Анхан шатны баримтыг үндэслэн ажил гүйлгээг үнэн зөв бүртгэж, тайлагнаагүй зөрчлийг арилган, давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
- Цаашид холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг “Туулын хишиг” ААТҮГ-ын дарга Э.Шинэсандаг, нягтлан бодогч П.Соль нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

“ПИЙК ОМ АУДИТ” ХХК-ИЙН

АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

Б.НАРАНЧИМЭГ

132504865

**АЛБАН ШААРДЛАГА, ТӨЛБӨРИЙН АКТЫН БҮРТГЭЛ,
ХЯНАЛТЫН ХУУДАС**

А. Албан шаардлага, төлбөрийн актын төсөл бэлтгэж, баталгаажуулах үеийн бүртгэл, хяналт

1. Ерөнхий мэдээлэл

1.1 Аудитын нэр		"Туулын хишиг" ААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн аудитын тайлан		1.2 Аудитын код		СЭА-2025/011/НА-СТА-ОНӨҮГ		
1.3 Аудит хийсэн үндэслэл		Төрийн аудитын тухай хуулийн 6.3.1, 8.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1		1.4 Аудитын төрөл		Санхүүгийн тайлангийн аудит		
1.5 Албан шаардлага / төлбөрийн актын дугаар		1.6 Огноо		2025.03.15		1.7 Мөнгөн дүн /төгрөгөөр/		599,000.0
1.8 Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох үндэслэл	Алдаа зөрчлийн товч утга		Тайлант оны 5 дугаар сард худалдан авсан 599.0 мянган төгрөгийн үнэ бүхий 2.5 тн нүүрсийг бараа материалын дансаар дамжуулалгүйгээр шууд зардлаар бүртгэж, тайлагнасан					
	Алдаа зөрчлийн ангилал		Хууль, тогтоомж зөрчсөн					
	Журмын заалт (4.2-оос аль тохирохыг оруулах)		4.2.1.11: "Хууль тогтоомж, зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал					
	Зөрчсөн эрх зүйн актын	Нэр	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль					
		Заалт	5.1.4, 13.1					
	Үндэслэл болгосон эрх зүйн актын	Нэр	Төрийн аудитын тухай хууль					
		Заалт	21.1					
		Нэр	Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаал					
Заалт		4.2.1.11						
1.9 Төлбөр барагдуулах хэлбэр / төгрөгөөр/		Улсын төсвийн дансанд				1.10 Төлбөр, зөрчил барагдуулах огноо		
		Орон нутгийн төсвийн дансанд						
		Тухайн байгууллагын дансанд				2025.09.15		

2. Үндэслэл болгосон гол нотлох баримтын талаарх мэдээлэл


№	Нотлох баримтын нэр төрөл	Дугаар	Огноо	Тайлбар
1	Бараа материалын тайлан		2024 он	
2	Мөнгөн хөрөнгийн журнал		2024 он	

3. Аудитын баг болон хариуцагчийн талаарх мэдээлэл

№	Аудитын багийн		Хариуцагч			
	Овог нэр	Албан тушаал	Байгууллагын нэр	Албан тушаал	Овог нэр	Холбоо барих хаяг, утас
1	Б.Наранчимэг	Аудитор	"Туулын хишиг" ААТҮГ	Дарга, Ерөнхий нягтлан бодогч	Э.Шинсандаг П.Соль	99215462 91112706

4. Албан шаардлага, төлбөрийн акт бэлтгэх үеийн чанарын хяналт

4.1 Чанарын хяналт хийсэн тэмдэглэл

№	Албан тушаалтан	Огноо	Чанарын хяналтаар өгсөн санал зөвлөмж	Гарын үсэг
1	Тэргүүлэх аудитор			

2	Аудитын менежер	<i>Д/Н</i>	—	<i>Д/Н</i>
---	-----------------	------------	---	------------

4.2 Албан шаардлага, төлбөрийн актыг хэвлэмэл хуудсанд хэвлэх зөвшөөрөл

№	Албан тушаал	Овог нэр	Огноо	Гарын үсэг
1	Тэргүүлэх аудитор	Ч.Энхтуяа		<i>Ч.Энхтуяа</i>
2				

5. Албан шаардлага, төлбөрийн актыг баталгаажуулж, хүргүүлэх үеийн баримтжуулалт

№	Үзүүлэлт		Мэдээлэл оруулах хэсэг	Гарын үсэг
1	Албан шаардлага, төлбөрийн актыг баталгаажуулсан тушаалын	Огноо		
		Дугаар		
2	Албан шаардлага, төлбөрийн актыг хүргүүлсэн албан бичгийн	Огноо		
		Дугаар		
3	Албан шаардлага, төлбөрийн актыг хүлээлгэн өгсөн	Огноо		2025.03.15
		Ажилтны	Овог нэр	Б.Наранчимэг
			Албан тушаал	Аудитор
4	Албан шаардлага, төлбөрийн актыг хүлээн авсан	Байгууллагын нэр		"Туулын хишиг" ААТҮГ
		Ажилтны	Овог нэр	Э.Шинсандаг
			Албан тушаал	Дарга
5	Албан шаардлага, төлбөрийн актын хэрэгжилтийг хариуцах	Газрын нэр		Пийк Ом аудит ХХК
		Ажилтны	Овог нэр	Б.Наранчимэг
			Албан тушаал	Аудитор
6	Тооцоолсон зөвшөөрүүлсэн үр өгөөж	Санхүүгийн	Тоо	
			Дүн	
		Санхүүгийн бус үр өгөөжийн тоо		